

Golomt Capital®

# ДЭЛХИЙН

---

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ

2025.09.15

## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

### ТОВЧ

- Oracle компани хэд хэдэн томоохон AI гэрээ байгуулсны дараа санхүүгийн таамгаа мэдэгдэхүйц нэмж хувьцаа ханш 40 гаруй хувиар өслөө.
- Инфляци одоогоор Холбооны Нөөцийн зорилтот 2%-аас өндөр байгаа ч хөдөлмөрийн зах зээлийн сулралыг харгалзан ХНС ирэх долоо хоногт хүү бууруулах шийдвэр гаргана гэж хөрөнгө оруулагчид хүлээж байна.
- 4-р сараас хойш Хятадын хөрөнгийн зах зээлд гарсан өсөлт нь голчлон дотоодын хөрвөх чадварт сайжирсан буюу мөнгөний нийлүүлэлтээс улбаатай байв.
- Үйлдвэрлэгчийн үнийн индекс (PPI) жилийн дүнгээр 8-р сард 2.9%-иар буурсан бөгөөд энэ нь дараалан 35 дахь сардаа сөрөг түвшинд хадгалагдсан үзүүлэлт боловч 7-р сарын 3.5%-ийн уналтаас бага зэрэг дээрдсэн байна.



### S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
<b>Дундаж</b>	<b>6,678</b>

# BIG BOOM FOR ORACLE CORP





## АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.09.08-09.14


### АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ӨСЛӨӨ.

9 сарын 16-17 болох АНУ-ын төв банкны мөнгөний бодлогын хурлаар богино хугацааны хүүг бууруулах магадлал өндөр байгаа тул АНУ-ын хөрөнгийн зах зээлийн голлох индексүүд бүгд өсөлттэй хаагдлаа. Мөн Oracle компани хэд хэдэн томоохон AI гэрээ байгуулсны дараа санхүүгийн таамгаа мэдэгдэхүйц нэмэгдүүлснээр хиймэл оюун (AI)-тай холбоотой өөдрөг хандлага нь хөрөнгийн зах зээлд эерэг нөлөө үзүүлэв.

Хэрэглээний үнийн өсөлт 8-р сард өссөн талаар Хөдөлмөрийн статистикийн товчоо Пүрэв гарагт мэдээлэв. CPI (хэрэглээний үнийн индекс) жилийн дүнгээр 2.9%-д хүрсэн нь 7-р сарын 2.7%-иас өссөн үзүүлэлт байв. Хүнс, эрчим хүчийг хассан үндсэн инфляци (core CPI) 3.1%-иар өсчээ. Үйлдвэрлэгчийн үнийн индекс (PPI) нь эсрэгээрээ 8-р сард саарч, жилийн 2.6%-ийн өсөлттэй гарсан нь өмнөх сарын 3.1%-аас буурсан үзүүлэлт боловч үндсэн түвшиндээ 2.7%-оос 2.8% болж бага зэрэг нэмэгдэв. Инфляци одоогоор Холбооны Нөөцийн зорилтот 2%-аас өндөр байгаа ч хөдөлмөрийн зах зээлийн сулралыг харгалзан ХНС ирэх долоо хоногт хүү бууруулах шийдвэр гаргана гэж хөрөнгө оруулагчид хүлээж байна. Ажил эрхлэлтийн сул үзүүлэлтүүдийн дараа Хөдөлмөрийн яам 9-р сарын 6-ны байдлаар долоо хоногийн ажилгүйдлийн тэтгэмжийн хүсэлт 263,000 болж өссөнийг (2021 оны 10-р сараас хойших хамгийн өндөр түвшин) мэдээлэв. Мөн 2025 оны 3-р сар хүртэлх нэг жилийн хугацаанд АНУ-ын ажлын байрны урьдчилсан тооцоог эргэн харж, өмнө нь зарласнаас 911,000-аар бага ажлын байр нэмэгдсэнийг зарлав.

Баасан гарагт Мичиганы Их сургуулийн Хэрэглэгчийн сэтгэл санааны индексийн урьдчилсан дүн гарлаа. Уг индекс наймдугаар сарын 58.2-оос буурч 55.4 болсон нь энэ оны 4-5-р сарын хамгийн бага түвшнээс дээш байгаа ч өмнөх сараас дордсон үзүүлэлт байв.

Golomt\_Capital created with TradingView.com, Sep 15, 2025 10:10 UTC+8





## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.09.08 – 09.14


### ХЯТАДЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ӨСӨВ

Богино хугацааны хөрөнгө оруулагчдын өөдрөг хандлага үргэлжилснээр Хятадын эх газрын хөрөнгийн зах зээл өсөлт үзүүлэв. FactSet-ийн мэдээлснээр, дотоодын CSI 300 индекс 1.38%-иар, Шанхайн нийлмэл индекс 1.52%-иар өссөн бол Хонгконгийн Hang Seng индекс 3.82%-ийн өсөлттэй хаагджээ. 4-р сараас хойш Хятадын хөрөнгийн зах зээлд гарсан өсөлт нь голчлон дотоодын хөрвөх чадварт сайжирсан буюу мөнгөний нийлүүлэлтээс улбаатай байв. Энэ нь компанийн ашиг орлого эсвэл эдийн засгийн эерэг мэдээллээс илүүтэйгээр хүүгийн түвшин бага байгаа энэ үед илүүдэл хөрөнгөтэй өрхүүд өндөр өгөөж хайж буйтай холбоотой гэж үзэж байна. Сүүлийн саруудад хиймэл оюун ухааны хөгжил, мөн Бээжингийн anti-involution бодлого болон үнийн дайныг хязгаарлах кампанит ажил хөрөнгө оруулагчдын сэтгэл зүйг эерэг болгожээ. Bloomberg-ийн мэдээлснээр, Пүрэв гарагт CSI 300 индекс 3-р сараас хойших хамгийн том өдрийн өсөлтөө үзүүлсэн бөгөөд энэ нь дотоодын технологийн компаниудын өсөлтөөр хөтлөгджээ.

Эдийн засгийн үзүүлэлтүүд: Хятадын эдийн засагт дефляцийн дарамт үргэлжилснийг статистик харууллаа. Үйлдвэрлэгчийн үнийн индекс (PPI) жилийн дүнгээр 8-р сард 2.9%-иар буурсан бөгөөд энэ нь дараалан 35 дахь сардаа сөрөг түвшинд хадгалагдсан үзүүлэлт боловч 7-р сарын 3.5%-ийн уналтаас бага зэрэг дээрдсэн байна. Харин хэрэглээний үнийн индекс (CPI) гурван сарын дараа анх удаа сөрөг гарч, жилийн дүнгээр 8-р сард 0.4%-иар буурсан нь хүлээлтээс давсан уналт байв. Тус уналт хүнсний үнийн бууралтаас шалтгаалжээ. Барууны ихэнх орнуудаас ялгаатай нь Хятад гурав дахь жилдээ дараалан дефляцийн байдалд байгаа бөгөөд Засгийн газар үнийн бууралтыг эргүүлэх гэж оролдож байгаа ч үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн олон жил үргэлжилсэн уналтаас шалтгаалан дотоодын эрэлт сул хэвээр байгаа нь үнийг тогтвортой өсгөхөд бэрхшээл учруулж байна.

Golomt\_Capital created with TradingView.com, Sep 15, 2025 10:11 UTC+8

Hang Seng Index Futures - 1M - HKEX O25,025 H26,605 L24,877 C26,476 +1,453 (+5.81%) +89 (+0.34%)



**Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд**

<b>E EARNINGS WHISPERS</b>									
<b>Most Anticipated Earnings Releases</b> for the week beginning <b>September 08, 2025</b>									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	

<http://eps.sh/cal> © 2025 Earnings Whispers

**Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд**

<b>E EARNINGS WHISPERS</b>									
<b>Most Anticipated Earnings Releases</b> for the week beginning <b>September 15, 2025</b>									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	

<http://eps.sh/cal> © 2025 Earnings Whispers